



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Өлзийт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/1/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Мандалговь хот 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn</p> <p>Аудитор: Д.Должинсүрэн Утас: 70593113 Цахим хаяг: Doljinsurend@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.5.1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт.....	10
3.5.2 Орлого бүрдүүлэлт.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.3 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
СХС	Сум хөгжүүлэх сан
БХС	Байгаль хамгаалах сан
ОННТ	Орон нутгийн нэгтгэсэн тайлан



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2022.03.25 № 86

танай _____ -ны № _____ -т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ГАСРАНДОРЖ ТАНАА**

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

0012020997

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,087,299.8	1,557,062.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	494,027.0	692,283.9
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	131,846.5	226,039.2
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	461,426.3	638,739.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		6,765,186.6	7,176,091.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	6,765,186.6	7,176,091.3
39200	Биет хөрөнгө		6,531,959.9	6,943,039.6
39300	Биет бус хөрөнгө	13	233,226.7	233,051.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		7,852,486.4	8,733,153.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		36,975.8	98,923.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	36,975.8	98,923.1
41300	Өглөг	17а, 17б	36,975.8	98,923.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		7,815,510.5	8,634,230.4
51	Засгийн газрын хувь оролцоо		7,815,510.5	8,634,230.4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		2,211,491.2	2,211,491.2
51200	Хуримтлагдсан үр дүн		4,246,588.6	5,065,308.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,357,430.7	1,357,430.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		7,852,486.4	8,733,153.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,253,429.2	3,794,073.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО		99,197.6	128,259.8
110	Орлогын албан татвар		39,319.7	50,219.1
1100	Хувь хүний орлогын албан татвар		39,319.7	50,219.1
113	Хөрөнгийн албан татвар		1,740.0	68,395.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж		58,137.9	9,645.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	431,363.1	1,203,234.2
120	Нийтлэг татварын бус орлого		431,363.1	1,203,234.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,722,868.6	2,462,579.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,884,208.4	2,924,561.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,884,208.4	2,924,561.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,038,184.7	2,806,188.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,083,411.4	1,112,538.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		135,279.3	146,634.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		153,462.2	191,759.1
2104	Хангамж, бараа материалын зардал		100,593.2	129,295.6
2105	Нормативт зардал		52,220.2	262,363.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		21,416.0	21,746.0
2107	Томилолт, зочны зардал		11,255.8	8,205.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		31,869.0	28,003.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		448,677.5	905,643.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		846,023.7	118,373.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		369,220.8	869,511.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		67,220.4	52,141.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		302,000.4	817,370.0

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,511,830.4	7,511,830.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,679.7	1,679.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,513,510.1	7,513,510.1
9	Тайлант үеийн үр дүн	302,000.4	302,000.4
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,815,510.5	7,815,510.5
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,815,510.5	7,815,510.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,349.8	1,349.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,816,860.4	7,816,860.4
19	Тайлант үеийн үр дүн	817,370.0	817,370.0
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,634,230.4	8,634,230.4

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,946,218.8	2,566,699.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	99,197.6	128,259.8
110	Орлогын албан татвар	39,319.7	50,219.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	39,319.7	50,219.1
113	Хөрөнгийн албан татвар	1,740.0	68,395.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	58,137.9	9,645.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,217.3	4,687.2
1181	Газрын төлбөр	920.6	4,958.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	54,000.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	124,152.6	142,768.7
120	Нийтлэг татварын бус орлого	124,152.6	142,768.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,722,868.6	2,295,670.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,482,010.0	2,039,821.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,482,010.0	2,039,821.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,632,525.1	1,908,936.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,082,559.4	1,106,752.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,750.4	149,747.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	153,462.2	190,341.6
2104	Хангамж, бараа материалын зардал	67,016.5	82,876.4
2105	Нормативт зардал	31,968.9	128,441.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,897.1	50,264.9
2107	Томилолт, зочны зардал	11,169.8	8,205.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,418.2	29,211.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,282.6	163,096.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	849,484.9	130,885.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	464,208.7	526,877.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	107,679.0	328,620.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	107,679.0	328,620.4
2200	Дотоод эх үүсвэрээр	107,679.0	328,620.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-107,679.0	-328,620.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-50,555.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	50,555.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	305,974.7	198,256.9
101	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	188,052.3	494,027.0

20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	494,027.0	692,283.9
----	---	-----------	-----------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,609,845.4	2,040,674.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,877,437.7	1,748,194.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,832,748.4	1,703,504.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,109,151.8	1,083,579.3
210101	Үндсэн цалин	745,972.3	723,667.7
210102	Нэмэгдэл	260,789.8	260,779.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,000.0	6,000.0
210104	Урамшуулал	96,389.7	93,132.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	154,928.7	147,065.4
210201	Тэтгэврийн даатгал	110,173.8	106,579.3
210202	Тэтгэмжийн даатгал	11,280.8	10,641.4
210203	ҮОМШО-ний даатгал	9,024.7	8,331.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,222.7	2,020.5
210205	Эрүүл мэндийн даатгал	22,226.7	19,493.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	178,160.7	176,926.9
210301	Гэрэл, цахилгаан	12,728.5	11,504.2
210302	Түлш, халаалт	160,497.1	160,497.1
210303	Цэвэр, бохир ус	4,935.1	4,925.6
2104	Хангамж, бараа материалын зардал	68,082.3	68,065.8
210401	Бичиг хэрэг	7,613.9	7,611.0
210402	Тээвэр, шатахуун	44,224.8	44,223.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,733.0	5,722.5
210404	Ном, хэвлэл	643.4	642.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,172.3	2,171.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,694.9	7,694.5
2105	Нормативт зардал	59,273.6	58,220.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,751.4	18,746.8
210502	Хоол, хүнс	32,943.4	31,901.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,578.8	7,572.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	64,942.1	64,923.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	32,472.6	32,461.8
210602	Тавилга	5,268.2	5,268.2
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200.0	200.0
210604	Урсгал засвар	27,001.3	26,993.7
2107	Томилолт, зочны зардал	10,182.0	8,120.0
210702	Дотоод албан томилолт	10,182.0	8,120.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,519.1	7,512.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,375.5	3,369.8
210803	Даатгалын үйлчилгээ	517.1	516.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	360.5	360.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	111.0	111.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,543.4	1,543.4
210807	Газрын төлбөр	861.6	861.6
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	750.0	749.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	180,508.1	89,090.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	173,903.9	82,489.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,604.2	6,601.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,689.3	44,689.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,689.3	44,689.3
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	4,371.9	4,371.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,359.6	20,359.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,446.9	11,446.9

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,510.9	8,510.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	597,829.0	292,480.9
2200	Дотоод эх үүсвэрээр	597,829.0	292,480.9
223001	Бусад хөрөнгө	597,829.0	292,480.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	134,578.7	-
230001	Эргэж төлөгдөх зээл	134,578.7	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,609,845.4	2,229,743.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,408,041.9	1,403,254.9
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,046,747.4	1,041,960.4
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	361,294.5	361,294.5
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	730,467.1	704,377.0
122005	Орон нутгийн төсвоос	730,467.1	704,377.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,160.5	8,880.9
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	26,160.5	8,880.9
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	445,175.9	113,230.4
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	69,214.1	76,507.5
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65,000.0	36,722.9
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	310,961.8	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	374,364.6
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	563,432.9
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6	6
610001	Төсвийн байгууллага	6	6
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	103	102
620001	Удирдах ажилтан	14	14
620002	Гүйцэтгэх ажилтан	59	57
620003	Үйлчлэх ажилтан	28	29
620004	Гэрээт ажилтан	2	2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		334,549.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ		334,549.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		253,140.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		23,172.6
210101	Үндсэн цалин		4,429.1
210104	Урамшуулал		18,743.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,682.1
210201	Тэтгэврийн даатгал		2,682.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		13,414.7
210301	Гэрэл, цахилгаан		406.0
210303	Цэвэр, бохир ус		13,008.7
2104	Хангамж, бараа материалын зардал		16,738.2
210401	Бичиг хэрэг		999.1
210402	Тээвэр, шатахуун		10,217.7
210404	Ном, хэвлэл		1,933.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мөргөчдийн устгал, ариутгал		469.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,118.2
2105	Нормативт зардал		70,406.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		56,011.1
210502	Хоол, хүнс		14,395.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		12,831.8
210601	Багаж, техник, хэрэгсэл		5,361.1
210602	Тавилга		197.8
210604	Урсгал засвар		7,272.8
2107	Томилолт, зочны зардал		85.0

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	85.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,325.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,179.3
210803	Даатгалын үйлчилгээ	54.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	58.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,483.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	87,154.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,329.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,700.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,700.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	43,700.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,708.8
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	37,708.8
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	334,549.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	334,549.4
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	101,241.5
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	83,443.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45,438.3
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	104,426.6
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.4

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Өлзийт сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Д.Должинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Өлзийт сум нь эрхэм зорилгоо “Төр иргэний оролцоог ил тод нээлттэй болгож иргэд олон нийтийн санал санаачилгад тулгуурлан төрийн бодлогыг шударгаар хэрэгжүүлнэ” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас сумын төсвийн 4 байгууллагын эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,924,561.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 29,245.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 20,471.9 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

3.5.1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 880,667.0 мянган төгрөгөөр буюу 11.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1.

Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31	Оөрчлөлт 3=2-1
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,087,299.8	1,557,062.1	469,762.3
МӨНГӨН ХӨРӨНГӨ	494,027.0	692,283.9	198,256.9
АВЛАГА	131,846.5	226,039.2	94,192.7
БАРАА МАТЕРИАЛ	461,426.3	638,739.0	177,312.7
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,765,186.6	7,176,091.3	410,904.7
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,765,186.6	7,176,091.3	410,904.7
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,852,486.4	8,733,153.4	880,667.0
НИЙТ ӨР ТӨЛБӨР	36,975.8	98,923.1	61,947.3
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	36,975.8	98,923.1	61,947.3
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,815,510.5	8,634,230.4	818,719.9
Засгийн газрын хувь оролцоо	7,815,510.5	8,634,230.4	818,719.9
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧ	7,852,486.4	8,733,153.4	880,667.0

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 198,256.9 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний зардлыг 564,479.0 мянган төгрөгөөр төсөвлөсөн болвч цар тахлын улмаас хил хаагдаж бараа бүтээгдэхүүний үнэ өссөн, зарим үйл ажиллагааг хязгаарлаж байснаас цаг хугацааны хувьд хойшлогдсон, суманд АЗ сертификаттай 1 хүн байсан зэргээс шалтгаалан 279,577.1 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан нь нөлөөлсөн.

Авлагын дансны үлдэгдэл 94,192.7 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас цар тахлын эмчилгээний 167,483.7 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгон, Эрүүл мэндийн төв авлага үүсгэн бүртгэсэнтэй холбоотой.

Бараа материалын үлдэгдэл 638,739.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 177,312.7 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн төвийн цар тахлын эм тариа, вакцин, вакцинжуулалтын ажлыг зохион байгуулахад шаардагдах эм, боох, хамгаалах хэрэгслийн үлдэгдэл өмнөх оноос 60,745.8 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр 48,744.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, ном худалдан авч, хандиваар 838,562.9 мянган төгрөгийн, бусад эх үүсвэрээс 55,525.0 мянган төгрөгийн хөрөнгө орлогод авч 10,105.6 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 6,428.6 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,634,230.4 мянган төгрөг болж 818,719.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.2 Орлого бүрдүүлэлт

Өлзийт сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 10 дугаар тогтоолоор Өлзийт сум тайлант онд 108,770.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 157,789.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 145.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого				
Хувь хүний орлогын албан татвар	33,100.0	50,219.1	17,119.1	151.7
Бууны албан татвар	1,900.0	1,582.0	-318.0	83.3
Улсын тэмдэгтийн хураамж	500.0	1,239.7	739.7	247.9
Малд ногдуулах албан татвар	20,000.0	66,813.3	46,813.3	334.1
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,000.0	179.5	-820.5	18.0
Газрын төлбөр	1,840.0	4,958.3	3118.3	269.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3,500.0	3,268.0	-232.0	93.4
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	24,130.0		-24,130.0	0
Дүн	85,970.0	128,259.9	42,289.9	149.7
Татварын бус орлого				
Хадгаламжийн хүүгийн орлого	19,800.0	22,932.3	3,123.3	115.8
Торгуулийн орлого	3,000.0	6,606.0	3,606.0	220.2
Бусад орлого				-
Дүн	22,800.0	29,529.3	6,729.3	168.0
Нийт дүн	108,770.0	157,789.2	49,019.2	145.1

Эх сурвалж: Өлзийт сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хувь хүний орлогын албан татварын орлого 17,119.1 мянган төгрөгөөр давсан нь “Эрдэнэс Таван толгой” ХК иргэдэд хувьцааны ногдол ашиг олгож, ногдол ашгаас суутгасан татвар, иргэд малчдын ноос ноолуурын урамшууллын татварыг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Бууны татвар 318.0 төгрөгөөр тасарсан нь татварын бааз буруу тооцсонтой холбоотой.

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 820.5 мянган төгрөгөөр тасарсан нь ковид цар тахлын улмаас айл өрх албан байгууллагууд элс хайрга ашиглаагүйтэй холбоотой байна.

Ан агнуурын төлбөр 24,130.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч цар тахлын улмаас аялал жуулчлал, хүний хөдөлгөөн зогссоноос аргал агнах зөвшөөрөл олгогдоогүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Өлзийт сумын ИТХ-ын 2020 оны 09 дугаар тогтоолоор сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,519,505.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,519,505.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

Өлзийт сумын ИТХ-ын 2021 оны 19 болон 21 дугаар тогтоолоор төсөвт 2 удаа өөрчлөлт хийж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг тус бүр 90,339.5 мянган төгрөгөөр өсгөн, 2,609,845.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Тус онд гарсан ковид-19 цар тахлаас шалтгаалан сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр хаасантай холбоотойгоор санхүүжилтийг өсгөн баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд сумын Засаг даргын хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 2,609,845.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,877,437.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 597,829.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 134,578.7 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,408,041.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 730,467.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 26,160.5 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 134,214.1 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 310,961.8 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,403,254.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 704,377.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 8,880.9 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 113,230.4 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 310,961.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 76,507.5 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 7,293.3 мянган төгрөгөөр давж, туслах үйл ажиллагааны орлого 36,722.9 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 25,277.1 мянган төгрөгөөр тасарсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого нь Сум хөгжүүлэх сангийн хүүгийн орлого бөгөөд тайлант онд шинээр нэмж зээл гаргаагүй байна.

Туслах үйл ажиллагааны орлогод Мал хамгаалах сангийн өвсний борлуулалтын орлогыг бүртгэдэг байна. Тайлант онд тендер шалгаруулалтаас шалтгаалан өвсний татан авалт төлөвлөсөн хэмжээнд хийгдээгүйгээс туслах үйл ажиллагааны орлого тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,040,674.8 мянган төгрөг буюу 78.2 хувьтай байгаа ба үүнээс хөрөнгийн зардал 292,480.9 мянган төгрөг, урсгал зардалд 1,748,194.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 51,733.9 мянган төгрөгийг улс, орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 101,241.5 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 83,443.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 45,438.3 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын нэмэлт орлого 104,426.6 мянган төгрөг, нийт 334,549.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин шимтгэлд 25,854.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 13,414.8 мянга, хангамж бараа материалын зардалд 16,738.2 мянга, нормативт зардалд 70,406.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 12,831.9 мянган төгрөг, томилолтын зардалд 85.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 22,325.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 91,483.8 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 43,700.0 мянган төгрөг нийт 296,840.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 37,708.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд ковидын нөхцөл байдал болон хаврын шороон шуурганы аюултай үзэгдэлд хүнд гарз хохирол амссан нутгийн иргэддээ тухайн нутагт хайгуулын болон ашиглалтын зөвшөөрөлтэй уул уурхайн 15 компани 73,300.0 мянган төгрөг, зам ашигласан 2 компани 12,000.0 мянган төгрөг, нутгийн зөвлөл 1,500.0 мянган төгрөг, нутгийн иргэдээс 14,941.5 мянган төгрөг, нийт 100,241.5 мянган төгрөгийн хандивыг өгсөн байна. Тухайн хандивын мөнгийг нутгийн Улсын онцгой комиссын үйл ажиллагаанд, гэр оронгүй болсон иргэдэд шинэ гэр авч өгөх, 7 оюутны сургалтын төлбөрт тус бүрт 1,000.0 мянган төгрөг, малчдад нүүхэд зориулж шатахууны зардал зэрэгт зарцуулж, үлдэгдэл 18,746.8 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн яамнаас нийт 152,673.2 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгслүүдийг аймгийн ЭМГ-аар дамжуулан хуваарилсан байна. Хуваарилсан эмийн нэг бүрийн үнийг оронгийн цэг, таслалын алдаанаас 10 дахин өсгөж ирүүлсэн 180 ширхэг эмийн үнэ нийт 2,197.7 мянган төгрөгийн алдаа, 36,451.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцины орлогыг аваагүй, зарлагыг тусгаагүй байсныг аудитын явцад залруулсан.

Сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны халаалтын төлбөрийг м.куб-ээр тооцож олгосныг 2022 оноос м.кв-аар тооцуулахаар болсон.

Сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилгад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 278,877.3 мянган төгрөгийн их засварын ажил хийгдсэн бөгөөд үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй тул гол асуудал байхгүй гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг дарга нь 2021 онд нийт 153 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулснаас 24 мэдээллийн хугацаа хоцроосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж үзлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол зөрчсөн зөрчлүүдийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд төсвөөс тавилга эд хогшил худалдан авсан, ажлын хувцас худалдан авч хэмнэлтийн горим зөрчсөн. Орон нутгийн хөгжлийн сангаас иргэд олон нийтийн саналыг аваагүй, жагсаалтаар эрэмбэлэгдээгүй, зориулалт бус хөрөнгө худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Засгийн газрын 2021 оны 2-р сарын 17-ны өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43-р тогтоолын, 1.4 /энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх/, мөн Төсвийн тухай хуулийн 60.3.1.-д /Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ/, 60.3.6-д /Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ/ дахь заалтуудыг тус тус зөрчсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн ОНХС-ийн худалдан авалт нь төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43-р тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт сумын Засаг даргын Тамгын газар, ОНХС-гийн илэрсэн зөрчил нь нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын төсвийн шууд захирагч нарт 306.7 мянган төгрөгийн 1 хугацаатай төлбөрийн акт, 5,484.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 9 албан шаардлага хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилт Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	306.7	1	306.7			100
Албан шаардлага	9	5,484.2	9	5,484.2			100
Зөвлөмж							
Нийт	10	5,790.9	10	5,790.9			100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн байгууллагуудын үндсэн хөрөнгө, бараа материалын зарцуулалтад дараагийн завсрын аудитаар горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд "Зөрчилгүй" санал дүгнэлт өгсөн байна.

Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 220,341.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 180,398.2 мянган төгрөгийн 7 алдааг аудитын явцад залруулж, 605.8 мянган төгрөгийн 2 алдааг буцаан төлүүлэх төлбөрийн акт, 39,337.4 мянган төгрөгийн 11 зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлагыг хүргүүлээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 18.1 хувийг залруулагдаагүй, 81.9 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Алдаа зөрчлийг ангиллаар нь харуулбал ихэнх буюу 180,604.1 мянга буюу 82.0 хувь нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай, 35,048.8 мянга буюу 19.5 хувь нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 4,688.6 мянга буюу 2.1 хувь нь дотоод хяналт хариуцлагатай холбоотой алдаа, зөрчил тус тус илэрсэн байгаа нь дотоод хяналтыг сайжруулан нягтлан бодогч нарын ур чадвар, хариуцлагыг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

4.1 Залруулсан алдаа

Уул уурхайн 3 ААНБ-ийн барьцаа 2,715.0 мянган төгрөгийн өглөгийг орлогоор бүртгэж, тайлагнасан алдаа илэрсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54.3.-т /Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана/ зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг аудитын явцад залруулсан.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сумын ИТХ-ын 2021 оны 09 дугаар тогтоолоор 2021 оны төсөвт тодотгол хийхдээ эд хогшил, урсгал засварын зардлыг 53,906.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 64,942.1 мянган төгрөг болгон баталж Засгийн газрын 2021 оны 2-р сарын 17-ны өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43-р тогтоолын 1.1-т /үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах/, 1.4 /энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх/ заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт тодотгол хийхдээ холбогдох хууль, тогтоомжийг баримтлан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулж байх.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт:

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг дарга нь 2021 онд нийт 153 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулснаас 26 мэдээллийн хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмыг уншиж судлан хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 7 дугаар сарын 25 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	ЗДТГ	2	16,494.9					2	16,494.9		
2	ЕБС	2	0.0					2			
3	ЦЭЦЭРЛЭГ	1	0.0							1	
4	ОНХС	1	18,553.9					1	18,553.9		
5	ИТХ	1	38.9					1	38.9		
6	ОННТ	2	53,906.1							2	53,906.1
	дүн	9	88,993.8	0	0	0	0	6	35,087.7	3	53,906.1
2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	ЗДТГ	3	627.0	1	35.10	1	205.835	1	386.1		
2	ИТХ	1	0.0					1			
3	ЭМТ	4	169,230.0	2	167,377.0	1	400.0	1	1,453.0		
4	ЕБС	3	14,100.0	2	11,689.4			1	2,410.6		
5	ЦЭЦЭРЛЭГ	1	1,033.0	1	1,033.0						
6	СОЁЛ	1	263.7	1	263.7						
8	БХС	1	2,715.0	1	2,715.00						
	дүн	14	187,968.8	8	183,113.2	2	605.8	4	4,249.8	-	-
	Нийт зөрчлийн дүн	23	276,962.6	8	183,113.2	2	605.8	10	39,337.4	3	53,906.1